

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 13

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	хувь
1	2	3	4	5	6	7	8
Мал аж ахуйн салбар							
1	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах	ОНТ- 1,350.0	Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангасан хувь	88.8	88,9	Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол, сумдын мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах шалгуур үзүүлэлт, аймгийн Засаг даргын 2023 оны А/459 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээний өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалт 12 сарын 08 өдрийн байдлаар 88,9 хувьтай хангагдсан./Аймаг сумдын аюулгүй нөөц бүрдүүлэлтэд 1,350.0 сая төгрөг зарцуулсан/.	100
2	Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх	ОНТ- 1,357.6	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	3	5	Аймгийн хэмжээнд малын тоо, толгойн албан татвараас хөдөө аж ахуйн чиглэлийн 5-н арга хэмжээнд зарцуулагдсан. Үүнд: 15 суманд Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө батлуулах-30,0 сая, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан 3 суманд инженерийн хийцтэй 13 худаг-337,5 сая, 7-н суманд 30 цооног гаргах-669,7 сая, 8 суманд үлийн цагаан оготнотой тэмцэх-127,9 сая, 7 суманд энгийн уурхайн 44 худаг сэргээн засварлах-192,5 сая, нийт 1,357.6 сая төгрөгийг зарцуулсан.	100

			Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /төгрөг/	300	330	Малын тоо, толгойн албан татварын хөрөнгөөр 5-н арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,357.6 сая төгрөгийг зарцуулсан.	100
3	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах	-	Эдийн засгийн эргэлтэд оруулсан мал тоогоор	83017	108791	2023 онд Дундговь аймгийн бэлчээрийн даацыг гаргахад 26.7 % бэлчээрийн нөөцтэй, 29.9 % бэлчээр хүрэлцээтэй, 41.3 % даац 1-3 дахин хэтэрсэн, 2 % нь даац 3-5 дахин хэтэрсэн үзүүлэлттэй гарсан. Дундговь аймгийн хэмжээнд 100 га бэлчээрт хонин толгойд шилжүүлснээр 50 мал байхаас 97 мал ногдож байгаа нь 47 мал илүү байна. Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг зах зээлд борлуулснаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх нэг арга хэмжээ юм. Өвлийн идэш арга хэмжээний үеэр бусад аймгуудаа манлайлж, идэвх санаачилгатай ажилласан. Таваарын буюу хэрэгцээний 848640 малаас 472877 малыг зах зээлд борлуулж эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. ХХААХҮЯам, аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулсан өвлийн идэш арга хэмжээнд тус аймгаас 12 сумын 63 малчин 278 тн мах худалдан борлуулсан.	100
4	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	УТ-150.0 ОНТ-1,191.5 Хувь хөрөнгө-74.0	Тухайн жилд шинээр гаргасан худгийн тоо	52	15	Улсын төсөв, орон нутгийн төсвийн 1,190,4 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Луус ,Өлзийт сумд инженерийн хийцтэй 18 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд 30 цооног шинээр энэ онд нийт 48 худгийг шинээр гаргаж бэлчээр усжуулсан. Сумдууд сүүлийн жилүүдэд орон нутгийн хөгжлийн	97,4

						сангийн хөрөнгөөр шинээр худаг гаргах нь нэмэгдэж байгаа бөгөөд энэ онд 43 уст цэгийг шинээр гарган усжуулсан байна. Бэлчээр усжуулалт өмнөх оноос 0,7 хувиар нэмэгдсэн.	
			Тухайн жилд сэргээн засварласан худгийн тоо	32	45	Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 205,7 сая төгрөгийн санхүүжилтээр Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан сумдад 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварласан.	
			Тухайн жилд хашиж хамгаалсан булгийн тоо	3	3	Орон нутгийн хөгжлийн сангийн 20, 0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг сумын Баянхошуу, Хулд сумын Дал, Сайхан-Овоо сумын Дэлгэрэхийн булаг нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалсан.	
5	Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх	Улсын төсөв-167.0	Бэлчээрийн хортон мэргэчтэй тэмцсэн талбайн хэмжээ мянган/га	29,5	30,0	Улсын төсвийн 167,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 10,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, энгийн механик аргаар 30,0 мянган га бэлчээрийн талбайд зохин байгуулсан. Энэ онд нийт 40,0 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион хээрийн техникийн үр дүн 83.7 хувьтай. Өмнөх оноос 10,5 га талбайгаар нэмэгдүүлэн тэмцсэн.	100
6	Малчдыг анхдугаар нутгийн хэрэгжүүлэх дэмжих аян орон түвшинд	ОНТ-15,0	Хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо		1	Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 сарын А/59 тоот тушаалын дагуу Малчдыг дэмжих анхдугаар аян-ыг орон нутагт хэрэгжүүлэх 6 заалт бүхий төлөвлөгөөний дагуу аяны арга хэмжээг зохион байгуулсан.	100

				0		“Малчдыг дэмжих анх дугаар аян”- ны хүрээнд мал аж ахуйн салбарыг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран Өндөршил омгийн адуу, Сайнцагаан омгийн хонь, Олдохын хүрэн бор омгийн тэмээ, Улсын хошой аварга малчин, Улсын аварга малчин,айраг, адууны эвент арга хэмжээний талаарх хөрөг нэвтрүүлгүүдийг хийлгүүлж үндэсний телевизээр цацаж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан. Өлзийт, Луус, Баянжаргалан, Говь-Угтаал сумдын малчдын зөвлөгөөнд оролцож 650 малчинд мал аж ахуйн талаарх мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан.	
7	Орон нутгийн тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах	ОНТ-0.2	Ашиглалт хамгаалалт сайжруулсан талбайн хэмжээ га	0	5	Аймгийн ИТХурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай 15 дугаар тогтоолоор Дэлгэрхангай, Өлзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын 64,9 мянган га талбайг сум дундын отрын тусгай хэрэгцээнд авсан. Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын Орон нутгийн тусгай хэрэгцээний Дундын нуруу орчмын 10 га талбайд бэлчээрийн хортон мэрэгчтэй Микробиологийн аргаар тэмцэж бэлчээрийн ашиглалтыг сайжруулсан.	100
8	Нийт үхэр сүргийг хавар, намрын технологит хугацаанд ялган тэмдэглэн ээмэгжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх	Малчид хувь хөрөнгө 5.0	Ээмэгжүүлсэн үхрийн тоо	363	100	Говь-Угтаал- 24, Баянжаргалан-50 Дэлгэрцогт-45 сумд нийт 119 үхрийг ээмэгжүүлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр улсын хэмжээнд хийгдэх байсан хэдий ч төсөв хөрөнгө шийдэгдээгүй тул хийгдээгүй харин өөрийн орон нутгийн нөөц боломжид тулгуурлан дээрх ажлыг гүйцэтгэсэн.	100

9	Нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	-	Бүртгэсэн үхрийн тоо	363	100	Ялган тэмдэглэж, ээмэгжүүлсэн нийт 119 үхрийн мэдээллийг малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 100 хувь хамруулсан.	100
10	Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад шилжүүлж ялган төвлөрүүлэх	Хувийн хэвшил-7.0	Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгч хувиар	0	20	Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед нь ялган суурилсан. 11790 хээлтүүлэгч малыг ялгаж, нийт ялгавал зохих хээлтүүлэгч малын 50,2 хувийг ялган суурилсан. Хуц 6421, ухна 5369	100
11	Сумын хөдөө аж ахуйн тасгийг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, бүтэц орон тоогоор нь ажиллуулах.	ОНТ сая -3.5	Мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь	44	44,1	Сумдын хөдөө аж ахуйн тасагт нийт 20-н албан хаагч ажиллаж байна.2023 онд Боловсон хүчний хангалт 44,4 хувьд хүрсэн. ХААИС-ийн Зоо инженер технологийн ангийг төгссөн оюутныг аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”ийн хүрээнд сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулсан бөгөөд төрийн албаны шалгалтад тэнцэн суманд ажиллахаар болоод байна. Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын тасгуудад шинээр 3 мэргэжилтэн ажиллаж байна.	100
Газар тариалангийн салбар							
12	Сумдад агро-ойн аж ахуй байгуулах, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэхэд газар, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	УТ-250.0 Хувийн хэвшил-22.5	Шинээр байгуулагдсан агро-ойн аж ахуйн тоо	-	1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүжилтээр 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын “ЭМ ЖИ ДИ” ХХК нь Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг 3 га талбайд байгуулсан. Тус талбайд улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс жимсгэнийн суулгац 1500 ширхэг нийт 2375	

						ш мод жимс, жимсгэнийн суулгацыг суулгасан Шинээр 1 агро ойн аж ахуй байгуулагдсан.	100
			Шинээр нэмэгдүүлсэн жимс, жимсгэнийн талбай хэмжээ га	62	67	Аймгийн хэмжээнд нийт жимс, жимсгэнэ тариалсан талбай 77,8 га болж энэ онд өмнөх оноос 6,5 га-аар нэмэгдсэн.	
			Өмнөх оноос нэмэгдсэн жимс, жимсгэнийн ургацын хэмжээ тн	2.8	3	Жимс, жимсгэнэ 5,5 тн-ийг хураан авч өмнөх оноос хураан авсан ургац 2,7 тн оор нэмэгдсэн.	
13	Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	УТ-179,5 хувийн хэвшил-18.7	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	-	1	Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжийн чиглэлээр 179.5 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдсан. Шинээр баригдсан хүлэмж 10*30 харьцаатай. Ажлын явц 80 хувьтай байна.	100
			Өвлийн хүлэмжид тариалсан талбай хэмжээ м.кв	1540	1640	Дэлгэрцогт сум 120м2, Өндөршил сум 100м2, Сайнцагаан сум 1860 м2 нийт Өвлийн хүлэмжид 2080 м.кв тариалалт хийсэн. Урд онтой харьцуулахад 300 м.кв нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
			Хураан авах ургацын хэмжээ тн	17,4	18	Нийт 16 нэр, төрлийн хүнсний ногоо тариалж 19,02 тн ургац хураан авч аймгийн хүнсний ногооны 1,5 хувийг хангаж байна.	
14	Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	Хувийн хэвшил-22.0	Шинээр нэмэгдүүлсэн талбай хэмжээ га	55	57	Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумд нийт 2 га талбайд 1700 ширхэг /улиас, хайлаас, агч, сухай/ 4 нэр төрлийн мод,бутыг тариалсан. Аймгийн хэмжээнд тариалангийн талбайг хамгаалж нийт 57 га-д ойн зурвас	100

						бүхий мод бут тариалж, өмнөх оноос 2 га талбайгаар нэмэгдсэн.	
Хүнсний үйлдвэрийн салбар							
15	2022 онд батлагдсан УИХ-ын 36 дугаар тогтоолд дотоодын үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээг хангахаар заасан, хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуй нэгжийг урамшуулж, дэмжлэг үзүүлэх	УТ-350.0	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	2	2	ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй хүнсний үйлдвэрлэлийг дэмжих “Хөрөнгө оруулалт”-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Сайнцагаан, Говь-Угтаал сумын хүнс үйлдвэрлэгч 4 ААНэгж хүсэлт өгсний дагуу ХХААХҮЯамны ХҮБХЗохицуулах газарт мэдээллийг хүргэж улмаар аймгийн арилжааны банкнуудад үйлдвэрлэгчдийн мэдээлэл ирж зээл судлагдаж “Жаргалант сор” ХХК 320,0 сая, Элбэг Дэнж ХХК 30,0 сая 2 ААН нийт 350,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдан үйлдвэрлэлээ өргөтгөн ажиллаж байна. -Элбэг дэнж ХХК нь төслийн хүрээнд энэ оны 8 сард багтаан зөөврийн сууцан дэлгүүр худалдан авч төмс хүнсний ногооны борлуулалтаа хийнэ гэж заасны дагуу 4:6 харьцаатай зөөврийн сууцан дэлгүүрийг ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна. Ирэх оны 6 сард 40тн-ын зоорийг төслийн зураг төсвийн дагуу барихаар бэлтгэл ажлыг хангаж байна.	100
16	Хүүхдийн хоол тэжээлийн болон хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихэр, хүнсний сав, баглаа боодлын үйлдвэрээс аймгийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинээр байгуулах буюу	УТ- 245.0	Дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	-	1	ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй хүнсний үйлдвэрлэлийг дэмжих “Хөрөнгө оруулалт”-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Сайнцагаан, сумын хүнс үйлдвэрлэгч 3 ААНэгж хүсэлт өгсний дагуу ХХААХҮЯамны ХҮБХЗохицуулах газарт мэдээллийг хүргэж улмаар аймгийн арилжааны банкнуудад үйлдвэрлэгчдийн мэдээлэл ирж зээлийг судалж, Мандалговь Хүнс ХХК 245,0 сая,	100

	байгаа үйлдвэрийг өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх					төгрөгийн санхүүжилтийг ХААН банкнаас авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Эргэлтийн хөрөнгө буюу түүхий эд материал, техник, тоног төхөөрөмж хүнсний зориулалтын хөргүүртэй түгээлтийн машин /1тн/, талх зүсэгч, уур гаргагч, доозлогч гурил хэрчигч /Турк/ зэргийг суурилуулснаар үйлдвэрийн бүтээмж өмнөхөөс 2 дахин нэмэгдсэн. Мөн нам даралтын 2 тогоо /орос/ авч суурилснаар ажлын байрны орчин нөхцөл сайжирсан үр дүнтэй байна.	
17	Аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчдад олгож буй хоолны шим тэжээлийг тооцож, хоол хүнсний зохистой хэрэглээний нормд хүргэсэн байна.	ОНТ 4.0	Нормд хүрсэн сургууль цэцэрлэгийн тоо	-	40	Хүүхдийн хоолны шим тэжээлийн үзүүлэлтийг Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лабораторитой хамтран шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Одоогийн байдлаар 31 цэцэрлэг, сургууль буюу 77,5 хувь хоолны дээжийг шинжилгээнд хамруулаад байна. Хамрагдсан цэцэрлэг, сургуулиудын хоолны дээжийн лабораторийн шинжилгээний үзүүлэлтийг дундчилж тооцоход Илчлэг /ккал/-988,6, уураг-8,8 гр, өөх тос-9,7 гр, нүүрс-ус-62,5 гр байгаа нь БШУСайд, ЭМСайд, Сангийн сайдын 2020 оны А/166/559/222 дугаар тушаалаар батлагдсан Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн /1-3 нас, 4-6,нас 6-11насны/ хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг дундчилсантай харьцуулахад 1 өдөрт авах ёстой уургийн -17,6 хувь, өөх тосны-14,2 хувь, нүүрс-усны -35,2 хувийг, Илчлэгийн 1020-1200 ккал авч байна.	77,5

18	Хүнсний зориулалтын агуулах, зоорь, тусгай тээврийн хэрэгсэл, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний лабораторийг бүртгэж, ашиглалтыг сайжруулах.	УТ-5.8 ОНТ-20.0	Хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн тоо	5	10	Аймгийн хэмжээнд байгаа хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн судалгааг авч ХХААХҮЯамны ХҮБХЗГазрын Худалдаа, нийтийн хоолны хэлтэст хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд хүнсний зориулалтын тээврийн хэрэгсэл нийт 12 байгаагаас 1-10 тн 5, 20-иос дээш тонн багтаамжтай 7 байна.	100
			Хүнсний зориулалтын агуулах, зоорины тоо	15	15	Махны зориулалтын хөргүүртэй болон гүн хөлдөөгч зоорь, агуулахын нийт тоо 18 байгаагаас 0,3-8 тн багтаамжтай-7, 10-50 тн багтаамжтай -8, 80-100 тн багтаамжтай-3 байна.	
			Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний лабораторийг бүртгэлжүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/	-	1	Аймгийн хэмжээнд Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лаборатори,МАЭЦЛаборатори, Мандалговь Хүнс ХХК дотоод хяналтын лабораториуд хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтүүдийг шинжилж дүгнэлт гарган ажиллаж байна. Сорилтын итгэмжлэгдсэн лаборатори нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 3685 үзүүлэлтээр шинжилгээг хийж, стандартын шаардлага хангаагүй 70 үзүүлэлтээр илрүүлсэн нь нийт үзүүлэлтийн 1,9%-ийг эзэлж байна.Үүнийг задалбал: Эрүүл ахуй нян судлалын лабораторид нийт 846 сорьцод 1790 үзүүлэлтээр хийснээс стандартын шаардлага хангахгүй 40 сорьц буюу 42 үзүүлэлт, Хими, хор судлалын лабораторид 514 сорьцод 1895 үзүүлэлтээр хийснээс стандартын шаардлага хангахгүй 14 сорьц 28 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэн байна. 7340 кг махны 77 сорьцод 25006 өндөгний 81 сорьцод, 360 литр сүү, сүүн бүтээгдэхүүний 18 сорьцод магадлан шинжилгээ болон хүнсний нян судлалын	

					<p>шинжилгээг стандарт, аргагүйн дагуу хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>Сайнцагаан сум нь малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт тавих, мал маханд шинжилгээ хийх зориулалт бүхий Мал эмнэлгийн магадлан шинжилгээний лабораторийн ажлын байрыг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар байгуулж, мал эмнэлгийн тусгай зөвшөөрөл бүхий "Тэтум ХХК"-д ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өгсөн. Энэхүү лаборатори нь аймгийн төвд худалдан борлуулагдаж байгаа махны гарал үүсэл, тухайн малчнаас бэлтгэгдсэнийг батлах, багийн малын эмчийн олгох баталгаа буюу кодыг шалгах, газар дээр нь үзлэг шинжилгээг хийх, МЭГ-тай хамтран маханд байгаа антибиотикийн үлдэгдлийг шинжлэх, сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний хольц, бохирдлыг тодорхойлох зэрэг үйлчилгээг үзүүлж байна.</p>	
19	<p>Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Хувийн хэвшил-1.2 УТөсөв-0.1</p>	<p>Сургалт сурталчилгаа зохион байгуулсан эсэх /тийм-1, үгүй-0/</p>	1	<p>1. Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2023 оныг "Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Зоогийн газар, кафе, цайны газрын нийт 23 тогооч нарт Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, "Фүүд Трэйнинг Консалтинг" -тай хамтран хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандарт, "Технологийн карт мөрдөх" журам, "Хүнсний ногооны хорогдлын норм тооцох аргачлал", "Хоолны шим тэжээлийн үзүүлэлт, Илчлэг тооцох аргачлал" "Хоолны газрын эрүүл</p>	100

				-	<p>ахуй”, GMP- Үйлдвэрлэлийн зохистой дадал”, “GHP-Эрүүл ахуйн зохистой дадал” сэдэвт нийт 16 цагийн хичээлээр мэдлэг мэдээллийг өгснөөс гадна онол дадлага хослуулан тосны шинэлэг чанарыг шалгах, 1 порц хоолны давсны агууламж зэргийг зориулалтын багажаар шалгаж туршиж үзсэн нь тогооч нарын мэдлэгт үр дүн, ач холбогдолтой сургалт боллоо. Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаатай суралцагчдыг танилцууллаа. “Хүнсний нарийн ногоогоор хийх хоолны технологи” сэдэвт сургалтыг /Японы олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа Үдийн хоолны төслийн хүрээнд болон аймгийн тогооч нарын зөвлөгөөн, сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж хувийн хэвшил болон сургууль цэцэрлэгийн нийт 22 цэцэрлэг, 18 сургуулийн тогооч нарт, Нийт 3 удаагийн сургалтаар 153 иргэнийг хамруулсан нь тогооч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн арга хэмжээ боллоо.</p>	
20	<p>Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулах</p>	<p>ОНТ-2.9 УТ-0.7</p>	<p>Орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг сурталчлан зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	-	<p>1</p> <p>1."Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд “Зүүн болон Говийн бүсийн үндэсний хоолны аварга тогооч, зөөгч шалгаруулах сургалт, ажил мэргэжлийн уралдаан" тэмцээн Сүхбаатар аймагт болж аймгаас “Гран при”, Зоогийн газар, кафе, “хүүхдийн хоол”, “Эмнэл зүй” “Оюутан” зэрэг 5 төрөлд манай аймгийн</p>	

						сургууль, цэцэрлэг, хувийн хэвшлийн нийт 9 тогооч оролцож амжилт үзүүлсэн. 2.“Дундговь - Түншлэл 2023” арга хэмжээнд оролцогч хоол үйлдвэрлэгчдийн дунд орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг сурталчлах үзэсгэлэнг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд малчид уламжлалт аргаар боловсруулсан сүү цагаан идээний төрлөөр нийт 61 иргэн, ААН оролцож үндэсний хоол ундааг сурталчилсан ажил болсон.	100
21	Аймгийн хэмжээнд махнаас гадна стратегийн бусад хүнсний улирлын нөөц бүрдүүлж, орон нутгийн хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байх	Хувийн хэвшил-604.0	Нөөцөлсөн махны хэмжээ /тн/	100	100	Орон нутгийн хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээг хангах, үнийг тогтвортой байлгах зорилгоор Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч ААНэгж “Номгон рашаан” ХХК, иргэн Дэмчигбаатар, Мөнхбат нар нийт -93,0 тн махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлж 2023 оны хавар зуны хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. Сайнцагаан сумын 2024 оны хавар зуны улирлын хүн амын хүнсэнд хэрэгцээлэх махыг 1 иргэн, 4 ААНэгж стандартын шаардлага хангасан хөргүүртэй болон гүн хөлдөөх агуулахад 735,5 тн мах нөөцөлсөн бөгөөд үхэр-26,5тн, хонь-339 тн, ямаа-360 тн, тэмээ-10 тн байна.	100
			Нөөцөлсөн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ /тн/	50	70	Аймгийн хэмжээнд хүнсний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжийн нөөцөд мах-730 тн савласан ус-23 тн, хуурай сүү-3,14 тн гурил-65 тн байна.	
22	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны	Хувийн хэвшил-438.5	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /тонн/		1	Сайнцагаан Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулж буй “Мал төхөөрөх” 4 цэгт үхэр-13, адуу -40, тэмээ-14, хонь-21800, ямаа-7200 толгойг төхөөрч маханд	100

	техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг нэмэгдүүлсэн байх.			-		шилжүүлснээр 487 тн мах бэлтгэж, аймгийн болон Улаанбаатар хотын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Мөн үйлдвэрийн аргаар 15,3 тн бууз банш хийж нийт 502,3 тн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар бэлтгэж хагас боловсруулсан байна.	
23	Органик түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, баталгаажуулалтын байгууллагыг байгуулах ажлыг эрчимжүүлэх, шинээр байгуулах.	-	Шинээр байгуулагдсан баталгаажуулалтын байгууллагын тоо	-	1	2023 оны 3 сард зохион байгуулсан Мэргэжилтний зөвлөгөөнөөр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны ХҮБХЗГазрын Органик хүнс хариуцсан ахлах мэргэжилтэн Д. Тунгалаг “Органик түүхий эд бүтээгдэхүүн, хамтын баталгаажуулалтын байгууллага”-ыг хэрхэн байгуулах талаар мэдээллийг” Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчид зэрэг 120 хүнд мэдээлэл сургалт өгсөн.	0
			Зохион байгуулсан сургалт, мэдээллийн тоо	-	1		
Хөнгөн үйлдвэрийн салбар							
24	Ноосон түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, хонь хяргах төхөөрөмжийг нэвтрүүлж түүхий эдийн чанар, гарцыг дээшлүүлэх	-	Хонь хяргах төхөөрөмжийн сургалтад хамрагдсан хүний тоо	10	15	НҮБ-ын Хүнс, хөдөө аж байгууллагаас олгосон хонь хяргах төхөөрөмжид түшиглэн 15 залуу малчинд цахилгаан хайчаар хонь хяргах сургалтыг зохион байгуулсан.	100
			Хонь хяргах төхөөрөмжийг нэвтрүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/	1	1	Хонь хяргах төхөөрөмжийг ашиглан Эрдэнэдалай, Өндөршил сумд 150 хонь хяргаж төхөөрөмжийг нэвтрүүлж эхлээд байна.	
25	Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх, нядалгааны үеийн гэмтлийг бууруулах	-	Арьс шир хуулах төхөөрөмж ашиглан бэлтгэсэн арьс, ширний тоо	61258	61300	Бог малын арьс, шир хуулах төхөөрөмжийг ашиглан 61308 ширхэг арьсыг зах зээлд бэлтгэн нийлүүлсэн.	100

26	“Хөх сав, канистргүй аймаг, сум” хөдөлгөөнийг үргэлжлүүлэн, ажлыг эрчимжүүлэх, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, хүнсний зориулалтын бус хуванцар савны хор хөнөөлийг сурталчлах	ОНТ- сая 0.1	“Хөх сав, канистргүй аймаг, сум” хөдөлгөөнийг иргэдэд сурталчилсан эсэх /тийм-1, үгүй-0/	-	1	“Хөх сав, канистергүй аймаг, сум” аяны хүрээнд химийн бодис савлагдах зориулалт бүхий хуванцар савны хор хөнөөлийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг 2 удаа зохион байгуулсны үр дүнд зориулалтын савны хэрэглээтэй айл өрхийн тоо 7320 буюу 50,5 хувь боллоо.	100
			Орон нутагт үйлдвэрлэж буй хүнсний зориулалтын савны тоо	2000	2200	Уламжлалт эко сав үйлдвэрлэл эрхлэгч ТЭББЭ ХХК нь энэ онд 5000 ширхэг хувин үйлдвэрлэж зах зээлд борлуулан 750,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Иргэдийн хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн байраа өргөжүүлэн ажиллаж байна. Тус аж ахуй нэгж нь 2018 онд ЖДҮХсангаас 200,0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.	
27	Дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн холбоог түшиглэн сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх.	ХХСан-18.8 ХЭДСан-10.0 ОНХС-18.0	Сургалтын тоо	2	2	"Хог хаягдлыг хэрхэн бууруулах", "Аюултай хог хаягдал гэж юу вэ" сэдвээр Сайнцагаан сумын Цэгц билиг сургууль, "Говийн-Ирээдүй" цогцолбор сургуулийн сурагчид, Политехникийн коллежийн оюутнуудад 3 удаагийн сургалт мэдээллийг БОАЖГ-тай хамтран зохион байгуулсан. Сайнцагаан сумын ЗДТГ нь ОНХСангийн хөрөнгөөр хог, хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор зөөврийн хог тээвэрлэх 3 дугуйт 2 ширхгийг 18,0 сая төгрөгөөр худалдан авч Хот тохижуулах газарт хүлээлгэн өгсөн. Аймгийн хэмжээнд 4 суманд дахивар цэг шинээр нэмэгдэж байгуулагдаж, аймгийн хэмжээнд дахивар цуглуулах 7 цэгтэй болсноор нийт 81 тн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дахивар авах цэгт	100

						цуглуулсан. Үүнээс дахин боловсруулах үйлдвэрт 40 тн дахивар нөөц тушаасан. Энэ онд 52 ангилан ялгах савыг шинээр байрлуулж нийт 311 хог ангилан ялгах савтай болж өмнөх оноос 52 -оор ахисан байна.	
			Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	30	80	Нийт 125 багш, сурагчид мэдээлэл өгсөн. Иргэд мэдээлэл авснаар орчны бохирдолгүй амьдрах, хог ангилан ялгах анхан шатны мэдэгдэхүүн, дадал хэвшилд суралцаж байна.	
Жижиг, дунд үйлдвэрийн салбар							
28	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох.	Хувин хэвшил-179.5	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуй нэгжийн тоо	-	1	Мөнгөлөг МД ХХК нь ЖДҮХСангаас 179,5 сая төгрөгийн зээлийг Өвлийн хүлэмжийн үйл ажиллагаа явуулахаар авсан. Барилгын явц 80 хувьтай явна. Зээл авснаар 2 ажлын байр шинээр бий болсон. Үүнээс тус газарт ажиллаж буй Улаанбаатар хотоос шилжиж ирсэн 1 иргэнийг тус газар ажиллуулж байна.	100
29	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд төсөв, санхүү, бусад дэмжлэг үзүүлэх.	Хувийн хэвшил 50.0	Дэмжлэг авсан иргэн, ААНэгжийн тоо	-	1	Улаанбаатар хотоос Сайнцагаан суманд шилжин ирсэн С.Амарбаясгалан нь 1200 м2 талбай бүхий 4 зуны хүлэмжийг барьж байгуулсан. Иргэнийг дэмжиж тариалалтын 1200м2 талбайг ХХААГ-аас өөрийн трактораар хагалж, хүлэмжээ хэрхэн барих, хүлэмжийн тариалалт хэрхэн хийх талаар аймгийн ерөнхий агрономич арга зүйн дэмжлэг өгч хамтран ажиллаа. Ирэх оны тариалалтын бэлтгэл ажил 100 хувь хангагдсан.	100
30	Орон нутгийн бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чанар	-	Бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуй нэгжийн тоо	2	3	Жайка Олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа Үдийн хоолны загвар төсөлд сонгогдсон Мандал, Говийн Ирээдүй сургуулийн хоол, хүнсний хангамжид орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл	

	стандартын шаардлага хангасан үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх					эрхлэгч 10 иргэн Бууцай, чинжүү, хулуу сонгино зэрэг 7 нэр төрлийн хүнсний ногоог нийлүүлж байна. Төрийн байгууллагад орон нутгийн үйлдвэрлэгч 9 иргэн, ААНэгж 15 нэр төрлийн хүнсний түүхий эд болон бараа бүтээгдэхүүн нийлүүлж байна.	100
			Нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийн дүн /сая төг/	70	100	Төрийн худалдан авалтаар орон нутгийн үйлдвэрлэгчид нийт 686,3 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлсэн байна.	
31	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх.	ОНТ-1,199.4 сая.төг	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан ААНэгжийн тоо	3	6	2023 онд ЖДҮХСангаас 11 ААНэгжид 1,199,400,000 төгрөг олгосон байна. Зээлд хамрагдсан ААН-үүд шинээр үйл ажиллагаа явуулж эхлээд байна. Өнгөрсөн оноос зээлийн хэмжээ 979,4 сая төгрөгөөр нэмэгдсэн. ЖДҮйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тоо өмнөх оноос 11 нэмэгдэж нийт 65 болсон. Хадгалагдсан ажлын байр-21, шинээр бий болсон ажлын байр-22 болсон байна.	50
32	"Хоршоог хөгжүүлэх сан"-ийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах	-	Эргэн төлөлтийн хувь (Хамгийн багадаа 5 хувь өсөх)	42,1	47,1	ХХСангаас энэ онд 10 сумын 68 иргэн, ААНэгжид 1,312.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Ингэснээр 85 ажлын байр хадгалагдаж, 73 ажлын байр шинээр бий болсон байна. Урд онуудад зээл авсан 225 зээлдэгчийн эргэн төлөлт 47.1 хувьтай, журмын дагуу 2023 оны 68 зээлдэгчийн үндсэн зээл, эргэн төлөлт хийгдэж эхлээгүй.	100
			Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн тоо (50 хувь бууруулах)	106	53	2011-2023 онуудад зээл авсан идэвхтэй 278 зээлдэгчээс 106 зээл нь муу зээл байсан. Үүнээс 53 зээлдэгч зээлээ хааж муу зээлдэгчийн тоо 50 хувь буурсан байна.	
Малын удмын сангийн чиглэлээр							

33	Гойд ашиг шимт малын гүн хөлдөөсөн үр болон шингэлсэн үрээр иргэд, малчид, фермер эрхлэгчдийн үхэр, хонин сүрэгт биотехнологийн дэвшилтэд арга технологиудыг ашиглан зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээ үзүүлэх	ОНТ-10.0	Тухайн жилд зохиомол хээлтүүлэг хийсэн малын тоо	380	400	Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд, өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч хээлтүүлэг хийсэн. Энэ онд 500 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийж, аймгийн хэмжээнд нийт 1850 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна.	100
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн чиглэлээр							
34	Экспортын чиг баримжаатай мах махан бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг тодорхойлох шинжилгээ, судалгаа.	УТ-10.0	Судалгаа хийгдсэн дээжийн тоо	-	80	Азийн 14 улсын Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний онлайн Флат Форум үүсгэх зорилгоор орон нутгийн брэнд болох хонь, ямааны мах, ямааны сүү, гүүний айраг, хөмүүл, таанын нарийвчилсан 80 дээжийг олон улсын байгууллагын лабораторид судлуулахаар судалгааны дээжийг хүргүүлсэн одоогоор хариу ирээгүй байна.	100
35	Тогтвортой арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүхий эдийн гэмтэл бууруулах. Технологи нэвтрүүлэх туршилт, судалгааг хэрэгжүүлэх.	УТ-1.0	Судалгаа хийсэн арьс ширний тоо	-	Бог-50 Бод-30	Бог малын арьс, шир хуулах төхөөрөмжийг ашиглан 61308 ширхэг арьсыг зах зээлд бэлтгэн нийлүүлсэн. Ямааны арьсанд хийсэн судалгаагаар ноолуур самнах үеийн самны гэмтэл, богийн арьсанд бөөдий, шивээний гэмтэл, үхрийн арьсанд гуурын гэмтэл адууны арьсанд тамганы гэмтэл үүссэн байна. Богийн-55, бодын 32 арьсанд гэмтлийг тодорхойлсон.	100
36	Тогтвортой ноолуурын үйлдвэрлэл хөгжүүлэх, түүхий эд бэлтгэлд ноолуур самнах үеийн ямааны тавлаг байдлыг	ОНТ-2.5	Тавлаг байдлыг хангуулах технологи нэвтрүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/	0	1	Өлзийт сумын ЗДТГазар, Төрийн соёрхолт, ямаа судлаач Б.Мандахтай хамтран улааны ямааны судалгааны ажлыг эхлүүлэн ноолуурын чиглэлийн ямаа үржүүлдэг 25 өрхийн 52 малчдад ямаа самнах үеийн	100

	хангуулах технологи нэвтрүүлэх.					тавлаг байдал, технологи зааварчилгаа, ноолуур бэлтгэх арга зүй өгч ажилласан. Малчид зааварчилгааны дагуу тавлаг байдлыг хангаж, ямаа самнах байр, дэвсгэр, сам, хөл боох уяа, ноолуур савлах шуудайг стандартын дагуу бэлтгэн 1,5 тн ноолуурыг бэлтгэсэн.	
Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны чиглэлээр							
37	Орон нутгийн тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын нөөц бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах	ОНТ-0.2	Сайжруулсан талбайн хэмжээ га	5	5	Аймгийн ИТХурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай 15 дугаар тогтоолоор Дэлгэрхангай, Өлзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын 64,9 мянган га талбайг сум дундын отрын тусгай хэрэгцээнд авсан. Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын Орон нутгийн тусгай хэрэгцээний Дундын нуруу орчмын 10 га талбайд бэлчээрийн хортон мэрэгчтэй микробиологийн аргаар тэмцэж бэлчээрийн ашиглалтыг сайжруулсан.	100
38	Орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бүс нутгуудын бэлчээрийн даацыг тодорхойлж, тухайн бүс нутгуудад отроор мал өвөлжүүлэх ажлыг зохион байгуулах	ОНТ-3.0	Отроор өвөлжиж, хаваржуулсан малын тоо	5000	5000	Сум дундын тусгай хэрэгцээний бүс нутаг болох Өлзийт сумын Тагт багийн нутагт бэлчээрийн даац тодорхойлоход ургац 0,3 центнер ургац муу байгаа нь мал өвөлжүүлэх, хаваржуулах боломжгүй байна. Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын сум дундын отрын бүс Дундын нуруу орчмын нутагт 5000 мянган толгой мал оторлуулах судалгааг гарган төлөвлөгөөтэй ажиллаж байна.	100
100%-34, 97,4%-1, 77,5%-1, 50%-1, 0%-1							95,3

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХШҮХ-ИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ – ИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Х.ДАШНЯМ